

ДАМЖИН ӨНГӨРӨХ БОЛОН ЗОРЧИХ ВИЗЭЭС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ФИЛИППИН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Филиппин Улсын Засгийн газар /цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэх/,

Аялал жуучлал, соёл, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх Монгол болон Филиппиний хооронд иргэд харилцан зорчих нөхцөлийг адил тэгш, харилцан ашигтай байх зарчмын дагуу хөнгөвчлөх зорилгоор

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

Нэгдүгээр зүйл

Филиппиний хүчин төгөлдөр паспорттай Филиппиний иргэд хорин нэг /21/ хоногоос илүүгүй хугацаагаар Монголд зорчиход дамжин өнгөрөх болон зорчих виз авах үүргээс чөлөөлөгдөнө.

Хоёрдугаар зүйл

Монгол Улсын хүчин төгөлдөр паспорттай Монголын иргэд хорин нэг /21/ хоногоос илүүгүй хугацаагаар Филиппинд зорчиход дамжин өнгөрөх болон зорчих виз авах үүргээс чөлөөлөгдөнө.

Гуравдугаар зүйл

Монгол Улсад Филиппиний иргэд, Филиппинд Монгол Улсын иргэд дээр дурдсанаас илүү хугацаагаар оршин суух бол тухайн улсын холбогдох эрх бүхий байгууллагаас шаардлагатай зөвшөөрлийг авна. Энэхүү зөвшөөрөл нь тухайн улсын хууль, журамд нийцсэн байна.

Дөрөвдүгээр зүйл

Энэхүү гэрээний заалтанд дурдсан иргэд Монголд болон Филиппинд оршин суух хугацаандаа гадаадын иргэдэд хамаарах зорчих, түр болон удаан хугацаагаар оршин суух хууль, журмыг сахин биелүүлэх бөгөөд хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэхийг хориглоно.

Тавдугаар зүйл

Монгол Улс болон Филиппиний Засгийн газар хүчин төгөлдөр бус паспорттай буюу шаардлага хангаагүй иргэнийг зөвшөөрөгдсөн ажиллах хүчин гэж үзэхгүй байх боломжтой бөгөөд тааламжгүй этгээд буюу нийгмийн амгалан тайван байдал, хэв журам, эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдалд аюул учруулна хэмээн үзэж нутаг дэвсгэртээ оруулахаас татгалзах эрхтэй.

Зургадугаар зүйл

1. Монголын Засгийн газар Филиппинд зорчсон аливаа иргэдээ дуртай цагт нь саадгүй буцаан нэвтрүүлнэ.

2. Филиппиний Засгийн газар Монголд зорчсон аливаа иргэдээ дуртай цагт нь саадгүй буцаан нэвтрүүлнэ.

Долдугаар зүйл

Монголын болон Филиппиний Засгийн газар нийгмийн хэв журмыг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс нөгөө талдаа дипломат шугамаар мэдэгдэж энэхүү Хэлэлцээрийн Зургадугаар зүйлээс бусад заалтын үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох эрхтэй.

Наймдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь гарын үсэг зурснаас нэг жилийн дотор хүчин төгөлдөр болно. Энэ хугацаа дусахаас гуч хоногийн өмнө цуцлах тухайгаа дипломат шугамаар мэдэгдээгүй бол энэхүү Хэлэлцээр цаашид тодорхой бус хугацаагаар сунгасанд тооцно. Харилцан тохирогч Талууд эхний жилийн дараа энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухайгаа нөгөө талдаа гуч хоногийн өмнө дипломат шугамаар мэдэгдвэл энэ өдрөөс хойш 90 дэх өдөр үйлчлэл нь зогсоно.

Зохих журмын дагуу холбогдох Засгийн газруудын эрх олгосноор энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцээрийг Манила хотноо 1994 оны 5 дугаар сарын 13-ний өдөр англи хэлээр байгуулав.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ ФИЛИППИН
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг